

Г.ГАЛСАНЖАМЦ

*ХСИС-ийн Эрдэм
шинжилгээ, хөгжлийн
хүрээлэнгийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэл
судлал төвийн эрдэм
шинжилгээний
ахлах ажилтан, ахлах
дэслэгч*

ЯЛТАН, ХОРИГДОГСДЫН ХАРИЛЦАА ДАХЬ ХЭЛ ЯРИАНЫ ОНЦЛОГ, ЭТГЭЭД ҮГ ХЭЛЛЭГ

Товч агуулга:

Хүмүүс хоорондын харилцаа дотроос нийгмийн өөрчлөлтийг хамгийн ихээр тусгаж байдаг хэсэг нь олон нийтээс хязгаарлагдмал, чөлөөт бус бүлэг бөгөөд тэдгээрийн харилцааны хэрэглэгдэхүүн буюу хэл ярианы онцлог, үг хэллэгийг хэрэглээ, үр дагаварынх нь талаас судалж, дүн шинжилгээ хийхэд чиглэгдэнэ.

Түлхүүр үг:

Ялтан, хоригдогсдын харилцаа, хэл яриа, хэл-сэтгэхүйн хамаарал, этгээд үг хэллэг,

Хууль, эрх зүйн болон улс төрийн тогтолцооны тодорхой хэлбэрээс үл хамааран хорих ялыг хэрэглэх явдал сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд хурдацтайгаар өссөн¹³⁹ бөгөөд манай улсын хувьд ч сүүлийн 5 жилийн байдлаар хорих ял эдлэгсдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.¹⁴⁰

Гэмт хэрэгтэй тэмцэх, бүх төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн хууль, эрх зүйн салбарын ажилтнууд судлах нь тухайн судлагдахууны талаар бүрэн мэдээлэл өгч чадахгүй байгаа ба үүнд сэтгэл судлал, социологи зэрэг салбар шинжлэх ухааны оролцоог нэмэгдүүлэх нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд ял эдэлж эдэлж буй ялтан, хоригдогсдод сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас сэтгэл зүйч мэргэжилтний орон тоог нэмэгдүүлж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн сэтгэл зүйчдийн зүгээс гэмт хэрэгтэн бие хүний сэтгэл зүйн онцлог, гэмт зан үйлийн учир шалтгаан болон хоорондын харилцааны онцлогийн талаар зохих судалгааг явуулж, тэдний харилцааны сэтгэл зүйн асуудлыг орчны харилцан үйлчлэл, нөлөөллийн явцад субъектүүд тэрхүү орчинд харилцан хамтын үйл ажиллагаагаа зохицуулах хэрэгцээ шаардлагатай уялдуулан авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэснээр харилцааны сэтгэл судлалын салбар, судлах хүрээ өргөжөөд зогсохгүй ялтан, хоригдогч бие хүний буюу эрх чөлөөний хязгаарлагдмал, чөлөөт бус бүлгийн харилцааг хэрэглээ, үр дагаварынх нь талаас сэтгэл зүйн шинжлэх ухааны судалгааны аргад тулгуурлан авч үзэх боломж бүрдэж байгаа юм.

Харилцааны хэрэглэгдэхүүн болох хэл яриа нь харилцаа, танин мэдэхүй, сэтгэлгээний хэрэглүүр, ухамсар, ой тогтоолт, мэдээллийн материаллаг үндэс, бусад хүмүүс

¹³⁹ Оюунболд, Г. Хорих ял: нээлттэй хаалттай дэглэм илтгэл., 2009

¹⁴⁰ ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн тасгийн 2015 оны 01 дүгээр улирлын тайлан

болон өөрийн зан үйлийг зохицуулан удирдах хэрэгсэл болдог гэж зарим судлаачид¹⁴¹ үзжээ. Мөн хэл яриагаар дамжин тухайн хүний туршлага, мэдлэг, сэтгэл зүйн төлөв байдал бусад хүмүүсийн хүртээл болж байдаг.

Хүний сэтгэцийн хөгжил, түүний ухаант, соёлт зан үйл төлөвшин тогтоход хамилцаа ихээхэн үүрэгтэй бөгөөд хүн бусад хүмүүстэй идэвхтэй харилцах явцад нийгэм, түүхээр бий болсон хэм хэмжээ, үнэт зүйл, үйл ажиллагааны арга туршлага, мэдлэг эзэмшиж, бие хүний хувьд төлөвшиж байдаг хэдий ч ялтан, хоригдогсдын хувьд нийгэм, олон нийттэй харилцан мэдээлэл солилцох, үгэн ба үгэн бус хэлбэрээр мэдээлэл дамжуулах, тухайн мэдээлэл дамжуулах явцад сэтгэл хөдлөл, үнэлэмжийн болон гоо сайхны нөлөө үзүүлэх зэрэг харилцааны үндсэн үүрэг хэрэгжих байдал хязгаарлагдмал шинжтэй байгаа нь ял эдлүүлэх ажиллагааны практикаас харагдаж байна.

Хүмүүс хоорондын харилцааны дотроос нийгмийн өөрчлөлтийг хамгийн ихээр тусгаж байдаг бүлэг нь эрх чөлөөний хязгаарлагдмал хэсэг ба тэдгээрийн харилцааны хэрэглэгдэхүүн буюу хэл ярианы онцлог, үг хэллэгийг үүсэл, утга, хэрэглээний онцлогтой нь холбон судалж, дүн шинжилгээ хийх нь сэтгэц-хэл шинжлэл төдийгүй харилцаа-соёлын холбоог танин мэдэхэд ихээхэн ач холбогдолтой гэж үзэж болохоор байна.

Хэл шинжлэлийн эрдэмтдийн бүтээлээс харахад "Этгээд үг хэллэг гэдэг нь утга зохиолын хэлний хэмжээнээс гажсан нийгмийн янз

бүрийн бүлгийн хүмүүсийн хэл яриандаа хэрэглэж буй хурдан хугацаанд хувьсан өөрчлөгдөж байдаг үгийн сангийн давхарга мөн"¹⁴² гэж тодорхойлжээ.

Хэдийгээр этгээд үг хэллэг нь харилцааны соёлын хэм хэмжээнд нийцэхгүй боловч нийгмийн сэтгэл зүйн илэрхийлэл болсон судлагдахууны хувьд үүсэл, гарлаар нь авч үзвэл 20 дугаар зууны дунд үед шинээр олон хот суурин бий болж, зорилго болон мэргэжлээрээ нэгдсэн хүмүүсийн бүлэг бий болсон нь этгээд үг хэллэгийг идэвхтэй хэрэглэх нөхцөлийг үүсгэсэн гэж зарим судлаачид¹⁴³ үзсэн байна.

Этгээд үг хэллэгийг нэвтэрхий толь бичигт "... мэргэжил болон нийгмийн зарим хязгаарлагдмал бүлгийн өвөрмөц хэл" /Линг. 1990. 43/, Б.Н.Головин "Мэргэжлийн болон мэдлэг боловсрол, ажил төрлийн хүмүүсийн хооронд хэлэлцдэг өвөрмөц үгийг хэлнэ" гэх мэтээр тодорхойлсон байдаг. Гэвч монгол хэл шинжлэлд "этгээд үг хэллэг" гэж нэрлэж буй тухайн ухагдахууныг бусад оронд болзолт хэл, нууц хэл, нийгмийн аялгуу, ангийн аялгуу, арго, жаргон, сленг гэх мэт янз бүрээр нэрлэж ирсэн байна.

Ажиглалтаас үзэхэд "болзолт болон нууц хэл" гэдэг нь тодорхой үг буюу дохиог орлох үүргээр нь нэрлэхийг тэмдэглэсэн байна. Харин "арго" гэдгийг франц, "жаргон" гэдгийг

¹⁴² Сүхбаатар Ц. Монгол хэлний найруулга зүй. УБ., 2004. 91 дүгээр тал

¹⁴³ Самбуудорж О. Эрдэнэсүвд Л. Монгол хэлний этгээд үг хэллэг, этгээд үг хэллэгийн товч толь. УБ., 2002

¹⁴¹ Доржжав Д. Харилцааны сэтгэл зүйн ертөнц. УБ., 2007

герман-орос, "сленг" гэдгийг англи хэл шинжлэлийн уламжлалд зонхилон хэрэглэж ирсэн нэр томъёо байна.

К.Косцинский "Арго" нь нийгмээс хоцрогсод болон гэмт хэргийн ертөнцийнхний хэрэглэдэг тусгай онцгой хэл юм" гэж үзээд харилцах зүйлээ нуух зорилгоор болон нийгмийн тодорхой хэсгээс тусгаарлах хэрэглүүрээр ашиглагддаг бөгөөд гэмт ертөнцийн дунд дэлгэрсэн харилцааны нэгэн арга "(Лингтв, 1990:43)" гэжээ.

Түүхэн үүднээс авч үзвэл арго нь дундад зууны үеийн хотжилт, нийгмийн баян ядуугийн ялгарал, гэмт хэргийн ертөнцтэй холбоотой үүсч эхлээд Парисын, сүүлдээ Францын, эцэстээ хил даван олон улсад гэмт хэрэгтний ертөнцийнхний этгээд үг хэллэгийг арго гэж нэрлэх болжээ.

Мөн хэл шинжлэлийн ном зохиолд жаргоныг дараах байдлаар тайлбарласан байдаг байна.

О.С.Ахманова "Жаргон бол нэг болон хэд хэдэн хэлний их багаар дураар сонгон өөрчилсөн үг, нийлмэл үгээс үүсч байгаа болон тухайн хэлний нэгдлийн бусад хэсгээс салах, хэлний тусгаарлал үүсгэх зорилгоор, заримдаа нууц үгийн үүргээр нийгмийн салангид бүлгийн ихэнхдээ (аман харилцаанд) хэрэглэж байгаа хэл. "(Ахманова, 1966:148) гэсэн байна.

Орос хэлний нэвтэрхий тольд "Ямар нэг жаргон нь энэ жаргоныхоо хязгаараас хальсан ч жаргоноороо хэрэглэгдэж байдаг үг хэллэгийг хэлнэ. Жаргон дандаа өөрчлөгддөг. Янз бүрийн жаргон бие биедээ шилждэг, үүнийг дундын жаргон гэнэ." (Русс, 1979) гэжээ. Жаргон нь эртний франц хэлний "*jarguiller* - жиргэх, шулганах", латинаар "*garrir* - жиргэнэх, шулганах" гэсэн дуу чимээ дуурайн нэрлэсэн үгээс

гаралтай ажээ.

Тэгэхээр жаргон нь арго шиг нийгмийн чөлөөт бус бүлгийн дунд бус, ихэнхдээ нийгмийн чөлөөтэй ижил мэргэжлийн бүлэг давхаргын хэл ярианы онцлог гэж болохоор байна.

Сленгийн тухай хэл шинжлэлийн ном зохиолд дараах байдлаар тайлбарлаж ирсэн байна. А.С.Ахманова "1.Мэргэжлийн хэлний ярианы хувилбар. 2. Бичгийн хэлэнд болон тухайн бүлэгт шууд холбоотой бус хүмүүсийн, ер нь хүмүүсийн хэл ярианд нэвтрэн орж байгаа, хэлний энэ ялгаанд ялангуяа сэтгэл хөдлөлийн өнгө ялгарааг үүсгэдэг аль нэг мэргэжлийн болон нийгмийн бүлгийн ярианы хувилбар. "(Ахманова, 1966:419) гэжээ.

Сленгийг өргөн хэрэглэх нь хэл яриаг бүдүүлэг болгож, хэлзүйн соёл, хэм хэмжээнд харшилдаг бөгөөд анх Британы гэмт хэрэгтнүүд өөрсдийн үг хэллэгээ нэрлэж байжээ. Хожим уг ухагдахуун нь аажмаар өөрчлөгдсөн нийгмийн янз бүрийн бүлэг давхаргын хэл яриаг тэмдэглэх болсон байна.

Сленг үгийн гарал нь тодорхой биш бөгөөд гэхдээ англи хэлний үгийн гарлын тольд "*Slang* -бүдүүлэг хэл" скандив гаралтай бөгөөд, исландын *Slyngva* "шидэж хаях, чулуудах" үгээс үүссэн ба энэ үг нь норвегийн *Slangja* "эрүүгээ хөдөлгөх", мөн *Slengjord* "сленг үг" гэсэн доромж үгүүдийг тэмдэглэсэн үгүүдтэй холбоотой юм (*Skeat*, 1965:490) гэжээ.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл арго, жаргон, сленг гэсэн нэр томъёо нь нэг зүйлийн тухай өгүүлсэн нэр томъёо бөгөөд тухайн нэр томъёоны аль нэгээр уг ухагдахууныг төлөөлөн нэрлэж болно. Жишээ нь, оросын хэл шинжлэлд "жаргон", монгол хэл

шинжлэлд "этгээд үг хэллэг" гэсэн нэр тухайн ухагдахууныг төлөөлж чадна гэх дүгнэлтийг хийж болох бөгөөд судалгааны чиглэл, багтаамж, зорилгоос хамааран тухайн нэр томъёог заагтай хэрэглэж болох байна.

Өөрөөр хэлбэр нийгмийн чөлөөт бус бүлгийн этгээд үг хэллэгийг "арго", чөлөөт бүлгийн этгээд үг хэллэгийг "жаргон", бүр өргөн хүрээтэй янз бүрийн давхаргын хэлний үгийн сангийн сэтгэл хөдлөлийн өнгө маягийг "сленг" хэмээн нэрлэх эх үндэс байна.

Дээр дурдсан хэл шинжлэлийн эрдэмтдийн хийсэн судалгаа, бүтээл нь харилцаа дахь этгээд үг хэллэгийн найруулга, хэлний хэм хэмжээнд хэрхэн тусгалаа олсон зэргээр хязгаарлагдаж, түүний харилцаанд гүйцэтгэх эерэг, сөрөг нөлөө, үүргийг тодруулах явдал орхигдсон байх талтай юм.

Э.Пүрэвжав нарын судалгаанаас¹⁴⁴ үзэхэд "харилцагчдын этгээд үг хэллэгийг ерөнхийд нь суралцагчдын, жолооч нарын, жүжигчдийн, наймаачдын, хоригдлын, хулгайч нарын этгээд үг хэллэг гэхчлэн төрөлжүүлэн ангилж болно" гэж үзээд 1930-аад оны хэлмэгдлийн үед шоронд хоригдогсдын дунд "бууны нохой - хоригдлуудын дунд хоригдлын дүрээр байж мэдээ цуглуулагч этгээд", "ногоон малгайт -дотоод яамны албан тушаалтан" гэх мэт олон этгээд үг хэллэг үүссэн гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны 100 ажилтан, гэмт хэрэг үйлдсэний улмаас шүүхээр шийтгэгдэн ял эдэлж буй 200

хоригдогчийг түүвэрлэн хамруулсан судалгаанаас¹⁴⁵ үзэхэд судалгаанд хамрагдсан хоригдогсдын 91.7 хувь нь ямар нэгэн байдлаар этгээд үг хэллэг хэрэглэдэг гэсэн нь тэдний хоорондын харилцааны өвөрмөц хэрэгсэл гэдгийн илрэл бөгөөд нас, хүйс, хорих ангийн дэглэм харгалзахгүйгээр нийтлэг байдлаар этгээд үгийг хэрэглэдэг гэж дүгнэж болохоор байна.

Мөн судалгаанд оролцсон алба хаагчдын 83 хувь нь ялтан, хоригдогсдын харилцаанд хэрэглэгдэх этгээд үг хэллэгийг бүрэн ойлгодог гэсэн бол анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүн 4-6 сарын дараа бага бүлгийн дунд болон хоорондын харилцаанд этгээд үг хэрэглэн ярих, утгыг бүрэн ойлгох, хэрэглэх явдал дэлгэрдэг гэж нийт албан хаагчдын 77 хувь нь үзжээ.

Үүнээс үзвэл ялтан, хоригдогсдын харилцаа нь хязгаарлагдмал шинжтэй бөгөөд үүний улмаас бага бүлэгт үүссэн этгээд үг хэллэг түгэн дэлгэрэх, түүнээс суралцах, ахуйн нэршлийн болон үйл ажиллагаанд хэрэглэгдэх байдал нь харьцангуй богино хугацаанд буюу анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээд "шорон"-ийн гэж нэрлэгдэж болох өвөрмөц утга бүхий харилцааны хэрэгслээс суралцаж байдаг байна. Хүмүүс хоорондын харилцааны нөлөөллийн дуурайх механизмийн илрэл бодитоор ажиглагдаж байна гэж дүгнэж болох ба энэ нь ихэвчлэн сэтгэлзүйн тодорхой байдал, үйл ажиллагаагаа хослуулж, зан үйлийн загварыг ухамсартайгаар дуурайх, хуулбарлах буюу аль нэг загварыг

¹⁴⁴ Пүрэвжав.Э, Монгол хэлний этгээд үг хэллэг УБ.,1996

¹⁴⁵ ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс 2013 онд явуулсан судалгааны тайлан

бүтээлчээр тусгах хэлбэрээр илэрч буйн жишээ юм.

Мөн судалгаанаас үзэхэд гэмт хэргийн зүйл ангиас хамаарч этгээд үг хэллэг хэрэглэх байдал ялгаатай биш байгаа ба зөвхөн хорих ангийн нөхцөлд, хоорондын харилцаанд хэрэглэгддэг харилцааны өвөрмөц хэрэгсэл болох төдийгүй гэмт хэрэг хийх явцдаа этгээд үг хэллэгийг үгээр бус, исгэрэх, алга, тагнай таших зэрэг дохио зангаа¹⁴⁶-г хэрэглэдэг нь ажиглагдаж байна.

Энэхүү судалгаагаар ялтан, хоригдогч нарын харилцааны соёл болон этгээд үг хэрэглэхэд нөлөөлж болох хүчин зүйлийг тодруулахад хамт олны орчин маш чухал нөлөө үзүүлдэг гэж ялтан, хоригдогсдын 86.5 хувь нь, боловсролын байдал чухал нөлөө үзүүлэгч хүчин зүйл гэж 76.5% үзсэн ба тэдний харилцааны, харилцааны соёлын элементийг бий болгон төлөвшүүлэхэд хамт олны харилцаа ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй юм.

Мөн боловсролын түвшин бол хүний харилцааны соёлд хүнлэг энэрэнгүй, боловсон, ёс зүйтэй байдлыг төлөвшүүлэхэд чухлаар нөлөөлдөг учраас этгээд үг хэрэглэх нөхцөл нь ял эдлэгсдийн боловсролын түвшин доогуур байгааг илтгэж байна. Судлаач Д.Отгонсүрэн "Этгээд үг хэллэгийг боловсрол муутай зарим нэг хүмүүс нилээд их хэрэглэгддэг бөгөөд энэ нь хүүхэд багачуудад этгээд үг

хэлээр хэлэлцэх сонирхол төрүүлэх түүнийгээ бат болгох сөрөг хандлагатай юм". (Отгонсүрэн, 1975, 32) гэж тодорхойлсонтой утга нийлж байна.

Түүнчлэн Оросын эрдэмтэн Л.С. Выготский "Үг бол хэл яриа сэтгэхүйн хооронд үүсэх аливаа нөхцөл хамаарлыг өөртөө багтаасан нэг ёсны амьд эд эс юм" гэж тодорхойлсон бөгөөд хэл яриа, үг нь ямагт юмс үзэгдлийн мөн чанарыг тодорхойлж, утга санааг нь баяжуулан хөгжүүлж байдаг учираас сэтгэхүйн үйлийн салшгүй хэсэг гэдгийг ялтан, хоригдогсдыг хэл, сэтгэхүйн хамаарлаас харж болохоор байна.

Дээрх бүхнээс ялтан, хоригдогсдын харилцаа, хоорондын хэл ярианы онцлог, этгээд үг хэллэгийн хэрэглээг нэгтгэн дүгнэн үзвэл:

- Харилцаанд тогтсон нэг хэвийн өнгө маяг, хэлбэр журмыг өөрчилж хэл яриагаа хөгжүүн болгох, өөрийн санаагаа бусдаас нуух, бүдүүлэг болон доромж аяс гаргах зэрэгтэй холбоотойгоор тэдний хоорондын харилцаанд хэрэглэгдэж, тухайн үүрэг нь үгүй болоход хэрэглээнээс гарч байдаг,

- Хоригдогч нарын харилцаанд ахуйн хүрээний үг хэллэг нийтлэг байхаас гадна бусдаас харилцаагаа нуух зорилгоор хэрэглэгддэг үгс тодорхой хугацаанд хувьсан өөрчлөгдөж ахуйн шинжтэй үгс тогтмол шинжээ хадгалдаг,

- Нас, хүйс, шашин шүтлэг, хорих ялын дэглэмээс үл хамаарч нийтлэг байдлаар этгээд үг хэллэгийг хэрэглэж байгаа нь ажиглагдаж байгаа ба хошин урлагийн зарим төлөөллийн тоглолт, онигоо, урлагийн хэлбэрээр

¹⁴⁶ Дохио зангаа гэдэг нь бие эрхтэн болон эд өлгийн тусламжтайгаар ямар нэгэн утга санаа, сэтгэлийн хөдлөл, аяг байдлыг илтгэхийг хэлдэг. Дулам.С Монгол бэлгэдэл зүй. Гутгаар дэвтэр, Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй, УБ.,2001